ХУЖИРТ

РАШААН СУВИЛАЛ

Гавъяа шагнал

- **Д.Сүхбаатарын нэрэмжит**
- **Алтангадас одонт**
- **Магадлан итгэмжлэгдсэн**
- **Чанарын удидлагын ISO-9001:2015**
- **Хөдөлмөрийн гавьяаны улаан тугын одонт**

Түүх домог

Шунхлай хэмээх ажигч гярхай гөрөөчин өвгөн шархадсан доголон бугыг Хужиртын анагаах увдистай шавар, рашаанд өглөө бүхэн ирж хэвтэж хэрхэн хурдан илаарьшин дэгдэн давхих болсон тухай ард олны дунд домог болон яригдсаар хүмүүний биеийг анагаах ид шидийн рашаан болох нь амьдралаар нотлогдож, өвгөн анчин Шунхлайн домог болон үлдэж, Гуа уулынх нь баруун сэрвэн хадтай өндөрлөгийг Шунхлай хэмээн өргөмжилж, сүслэн залбирдаг болсон ажгуу.

Танилцуулга

Хужирт рашаан сувилал нь 1939 онд 40 ортой 1 их эмчтэй “Партизаны амралт” нэртэйгээр байгуулагдсан Монгол улсын ууган сувиллын нэг билээ. Өнөөдөр манай сувилал орчин үеийн анагаахын шинжлэх ухааны нэгэн томоохон салбар болон хөгжиж байгаа “Сэргээн засах”-ын салбарт томоохон байр суурь эзэлж, өрнө, дорнын анагаах ухааны арвин баялаг арга туршлагыг сүүлийн үеийн шилдэг ололттой зүй зохистой хослуулан “Хужиртын хөх сувд” хэмээн алдаршсан

халуун рашаан, “Хужиртын хар сувд” хэмээх эмчилгээний шаврыг эмчилгээ, үйлчилгээндээ голлон ашиглаж өндөр үр дүнд хүрч, ард түмнийхээ хайр хүндэтгэл, итгэл, найдварыг хүлээн Хужиртын рашаан сувиллын эмч, сувилагч, ажилтан албан хаагчид бид бүхэн бүтээлч сэтгэлгээ, эерэг хандлагыг түгээн олон улсын жишигт хүрсэн эмчилгээ, үйлчилгээг Монгол оронд бий болгох зорилт тавин рашаан сувиллуудаас анх удаа олон улсын чанарын удирдлагын ISO-9001-2015 стандартыг ханган жилийн 4 улирлын турш ажиллаж байна.

ХУЖИРТ РАШААН СУВИЛАЛ ЯВАХ ГАЗРЫН ЗУРАГ



Байршил: Орхон голын сав газар, Хангай нуруун салбар, Шунхлай, Гуа,Шивээт уулсын дунд

Далайн түвшнээс: 1660 метр
Аймаг: Өвөрхангай
Сум: Хужирт
Улаанбаатар хотоос: 390 км хатуу хучилттай замаар холбогдсон
what3words app: ///convey.mystery.figurative

www.hujirt.mn

Хужирт рашаан сувилал

77115858, 80398089, 91913860

Эмчилгээ

Орчин үеийн уламжлалт анагаах ухааны ололт амжилтыг дэвшилтэт технологи, Хужиртын байгалийн халуун рашаан, шавартай хослуулан олон жилийн мэдлэг, ур чадвар, дадлага туршлагатай эмч, сувилагч нар таны биеийн онцлогт тохируулан дараах эмчилгээнүүдийг хийж байна.

Эмчлэх өвчний заалтууд

1. Тулгуур хөдөлгөөний эрхтэний өвчнүүд:

- Ревматизмын гаралтай үе мөчний архаг үрэвсэл
- Бруцеллёзын гаралтай үе мөчний архаг үрэвсэл
- Ревматиодный гаралтай үе мөчний архаг үрэвсэл
- Яс сийрэгжих өвчин
- Ясны бороожилт удаашралт
- Хүзүүний болон нурууны жийргэвчнүүдийн шохойжилт
- Үе хоорондын яс ургалтууд
- Үе мөч болон ясны хугарлын үлдэцүүд
- Төрөлхийн түнхний мултралт, түүний үлдэц
- Түнхний дутуу хөгжил
- Нуруу нугасны гэмтлийн үлдэц
- Нуруу нугасны хагалгааны дараах байдлууд
- Булчин шөрмөсны архаг үрэвсэл

2. Захын болон төв мэдрэлийн системийн өвчнүүд:

- Нүүрний мэдрэлийн архаг үрэвсэл
- Гурвалсан мэдрэлийн архаг үрэвсэл
- Мэдрэлийн сульданги, ядаргаа
- Ууц нуруу, мөр, хүзүү, цээжний мэдрэлийн архаг үрэвсэлүүд
- Полиневрит
- Вегетатив мэдрэлийн сульданги, нойргүйдэлт
- Полимиелитын үлдэцүүд
- Дээд болон доод мөчний мэдрэлийн архаг үрэвсэлүүд
- Хүүхдийн мэдрэлийн нуруу, нугасны саа, саажилт

3. Хоол боловсруулах эрхтэний өвчнүүд:

- Ходоод болон нарийн , бүдүүн гэдэсний архаг үрэвсэл
- Цөсний хүүдийн архаг үрэвсэл, чулуугүй
- Хэвлийн хөндийн хагалгааны дараах наалдац

4. Амьсгалын замын өвчнүүд:

- Цагаан мөгөөрсөн хоолойн архаг үрэвсэл
- Багтраа сэдрэлийн бус үе
- Архаг хатгаа
- Пневмоконизы, силикоз, антрокоз

5. Бөөр шээсний замын өвчнүүд:

- Бөөрний архаг үрэвсл
- Давсагны архаг үрэвсэл
- Түрүү булчирхайн архаг үрэвсэл

6. Эмэгтэйчүүдийн өвчнүүд:

- Үр дамжуулах хоолойн архаг үрэвсэл
- Анхдагч болон хоёрдогч үргүйдэл

7. Арьсны өвчнүүд:

- Хайрст үлд
- Намарс буюу экзема
- Нейродермит, Атопикдерматит
- Харшлын гаралтай арьсны архаг үрэвсэлүүд
- Витилиго – арьс цайх өвчин

"Хужиртын хөх сувд" Рашаан

Хужиртын рашаан нь байгалиасаа мөнхийн халуун заяагдсан, бие махбодын эд эсийн түвшинд атом молекул био энерги, биохимийн онц гайхамшигтай, эмчилгээний нөлөө үзүүлдэг, цахиурын хүчлээс гадна фтор, азот, карбонат, гидрокарбонат, натри, кали, хүхэр ус төрөгч, нүүрстөрөгч, радон-с бүрэлдэн тогтсон байгалийн халуун рашаан юм.

Рашаан нь:

- Тулгуур хөдөлгөөний эрхтний өвчин,
- Захын болон төв мэдрэлийн систем,
- Арьс, бөөр, шээсний зам,
- Амьсгалын замын өвчин,
- Эмэгтэйчүүдийн өвчнүүдэд нэн сайн.



"Хужиртын хар сувд" Шавар

Хужиртын шаварт кальц, магни, төмөр, хөнгөн цагаан, манган, сульфат, цахиурын полимер, хагас ислүүд, хөнгөн цагааны исэл, төмрийн исэл, болон ургамлын ялзмагийн хольцтой хүхэрлэгээс бүрддэг.

Шавар эмчилгээ нь:

-үе мөч, тулгуур эрхтний өвчнүүд,
-эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нөхөн үржихүйн тогтолцоо,
-мэдрэл, арьс, бодисын солилцооны эмгэг зэрэг өвчнийг эмчлэн арьсыг толигор болгож, биеийг хоргүйжүүлэн цусны эргэлтийг сайжруулна.

Бид ОХУ, БНХАУ, БНСУ-д үйлдвэрлэсэн, сүүлийн үеийн дэвшилтэт технологийн аппарат, бие махбодод үзүүлэх сөрөг нөлөөгүй багаж төхөөрөмжөөр дотор эрхтний архаг үрэвсэлт өвчин, мэдрэл, үе мөч, нурууны өвчнүүд, үрэвслийн эсрэг, өвдөлт намдаах, эдийн тэжээл цусан хангамжийг нэмэгдүүлэх зэрэг эмчилгээний хэд хэдэн үйлчлэлийг зэрэг үзүүлж чадах онцлог давуу талтай Франклизация, Искра, Ультразвук, Лазер, Алмаг-2, Алмаг-3, УВЧ, гэрэл эмчилгээ, цахилгаан эмчилгээ гэх зэрэг **21** гаруй нэр төрлийн физик эмчилгээний багаж тоног төхөөрөмж ашиглан эмчилгээ хийж байна.

Физик эмчилгээ

Алмаг-3

Алмаг-3 аппарат нь тархины цусан хангамжийг сайжруулж хаван, үрэвслийг багасгаж өвчин намдаана. Артерийн даралт бууруулах, төв мэдрэлийн системийг тайвшруулж нойргүйдлийг эмчилнэ.

Франклизация

Франклизация нь өндөр хүчдэлийн тогтмол гүйдлийн цахилгаан талбайгаар үйлчлэн, тайвшруулах, хэсэг газрын тэжээлийг нэмэгдүүлэх, өвчин намдаах, үрэвслийг багасгах, цагаан мөгөөрсөн хоолойн цэр, салстыг гадагшлуулан үйл ажиллагааг сайжруулна.

УВЧ

Эд эсийн цэнэгжсэн хэсгийг ажиллагаанд оруулж цахилгаан энергийг дулаанд шилжүүлэн уургийн молекулын холбоог задална. Уураг тархинд сэрэх процесс хүчтэй болж эд, эрхтний тэжээл, нөхөн төлжилт сайжирна.



Электрофорез

Кальцихлорид, пирамидон, магнизм новокайн, рашаан, шавар, гүүний саамтай электрофорез эмчилгээ хийж байна. Эдгээр аппарат нь эд эсийг нэвчүүлэх замаар үйлчилж булчин сулруулах, өвчин намдаан үрэвсэл дарна. Эмэгтэйчүүдийн эмчилгээнд ялангуяа умайн дайвар эд, өндгөвчний сувгийн наалдангид цэвэр алое шүүс, рашаантай элекрофорезийг хийж байна.

Ультразвук

Бодисын солилцооны өөрчлөлтийн улмаас үүссэн өвчинд үрэвсэл даран намдааж үйлчилнэ.

Цахилгаах бээлий болон оймс

Хүзүү, нуруу, толгойны цахилгаан массаж, хөлийн улаан туяа 2 янзын цахилгаан оймс, интерференц, хөлийн улны цахилгаан массажны аппаратуудыг суурилуулснаар цус, лимфийн урсгалыг сайжруулж өвчин намдаан үрэвсэл эмчилнэ.

Физик, туяа болон гэрэл эмчилгээг рашаан болон шавартай хослуулан хийдэг ба туяаны харшилтай, хэт мэдрэг, биедээ металь суулгацтай (үе холбогч, хадаас, төмөртэй) хүмүүс орохыг хориглоно.

Гэрэл эмчилгээ

Гэрлэн эмчилгээнд Свет ванн, Соллюкс, улаан туяа, TDP аппаратууд, хүзүү, нурууны татлагын аппарат, давсан зам зэргээр эмчилж байна.

Гэрлэн ванн

Гэрлэн ванн нь хэсэг газрын цусан хангамжийг сайжруулж, судас өргөсгөх, эд эсийн тэжээлийг нэмэгдүүлэх, шархны эдгэрэлт нөхөн төлжилтийг хурдасгах үйлчилгээтэй.

Хэт ягаан туяа

Цусан хангамжийг сайжруулж судас өргөсгөх, эд эсийн тэжээлийг нэмэгдүүлэх, үрэвслийг шимэгдүүлж нөхөн төлжилтийг хурдасгана.

TDP

Уг шарлагын аппарат нь захын мэдрэлийн эсийн цусан хангамжийг сайжруулж, үрэвслийг намдааж, шархны эдгэрэлтийг хурдасгаж, сорвижилт наалданги багасган өвчин намдаан хаван хавдар буулгана.

Соллюкс

Үрэвслийн голомтыг шарж дархлааны эсүүдийг татдаг бөгөөд энэ нь эдгэрэлтийг хурдасгаж үрэвссэн хэсгийн хаван багасгана.

Бусад эмчилгээ

Бариа засал

Монголын уламжлалт анагаах ухааны оношилгоонд тулгуурлан, хий арвидсан, ядаргаа сульдал урхаг өвчний үед тамиржуулан, шимжүүлэх сэргээх үйлдэлтэй эмчилгээний арга болно.

Цус харвалт болон нуруу нугасны гэмтлийн дараах саа саажилтыг хөдөлгөөн заслаар эмчлэх нь өвчтөний өдөр тутмын үйл ажиллагаа, хөдөлгөөний чадварыг хамгийн боломжит дээд түвшинд хүргэх чадвар алдалтыг бууруулна.

Хөдөлгөөн засал

Хашчулуун ор

Хаш чулуу халахаараа өөрөөсөө тодорхой долгионы урттай дулаан буюу нил улаан туяа ялгаруулж, үйлчлүүлэгчийн биеийн гүнд нэвтэрч өвдөлт намдаан, цусны эргэлтийг сайжруулж, стресс бухимдлыг багасган тайвшруулж булчингийн уян хатан байдлыг нэмэгдүүлдэг.

Хүний биед хуримтлагдсан хор гадагшилж бодисын солилцоо сайжирч бие махбодын үйл ажиллагаа сэргэж нойргүйдэл ядаргаа тайлагдана. Давхар хэт улаан туяа буюу хасах ион гаргаж цахилгаан соронзон долгионыг өөртөө шингээн авснаар цусны эргэлтийг сайжруулан өвчин намдааж үрэвсэл дарна.

Хор тайлах



Өрөө байр



Та эрүүл мэндийн даатгалаа тасралтгүй **6** жил төлсөн бол **7** хоногийн байр, хоол, эмчийн үзлэг, эмчилгээний нийт дүн өрөөний сонголтоос хамаарч дараах үнэтэй байна

Энгийн өрөө

Эрүүл мэндийн даатгалтай **490,000₮**
Эрүүл мэндийн даатгалгүй **740,000₮**
Тэтгэврийн групптэй **490,000₮**

2 ортой өрөө

Эрүүл мэндийн даатгалтай **420,000₮**
Эрүүл мэндийн даатгалгүй **670,000₮**
Тэтгэврийн групптэй **420,000₮**

3-4 ортой өрөө

Эрүүл мэндийн даатгалтай **410,000₮**
Эрүүл мэндийн даатгалгүй **660,000₮**
Тэтгэврийн групптэй **410,000₮**

5-6 ортой өрөө

Хоолны цагийн хуваарь

8:00	цагаас Өглөөний цай
11:00	цагаас Бага үдийн цай
13:00	цагаас Өдрийн хоол
16.00	цагаас Их үдийн цай
19:00	цагаас Оройн хоол

Тэтгэврийн болон группт багтах хүмүүс үндсэн төлбөрөө төлж, сувилуулж дууссаны дараа өөрийн харьяа хорооны халамжийн байцаагчид Илгээх бичгийн канондсон хувь И-Баримт, Автобусны 2 талын билетээ өгч, нийт зардлын **50%** буцаан авах боломжтой

Люкс өрөө

2 ортой өрөө

Эрүүл мэндийн даатгалтай	**755,000₮**
Эрүүл мэндийн даатгалгүй	**1,005,000₮**
Тэтгэврийн групптэй	**755,000₮**

Гам барих зөвлөгөө

Гам хийх хугацаа нь эмчилгээ хийсэн өдөр, цаг минутаас эхлээд эмчилгээ дууссанаас хойш хүний биеийн байдлаас шалтгаалан 14-21 хоног хүртэл хугацаанд гам дэглэмийг хатуу сахина. Халуун хоол цай ууж идэхэд хөлрөхгүй болсон үед гам тайлагдлаа гэж үздэг.

Биед чинь ямар нэг зовуурь илэрвэл шаналгаа мэдэгдвэл сувилагч болон эмчид яаралтай мэдэгдэн үзүүлж яаралтай тусламжийг цаг алдалгүй авах шаардлагатай.

Эмчилгээний явцад ямар ч өвчин дахин хөдлөх цусны даралт ихдэх, зүрхээр өвдөх, амьсгаадах хандлага үргэлж дагалдах тул та өөрөө байнга хэрэглэдэг эмүүдээ болон зүрх, даралтны эмээ биедээ үргэлж авч хэрэглэж байх.

Барих гам дэглэм

Чихээ бөглөн, малгай өмсөх, дулаан хувцаслан (хэт бэгнэхгүй) бороо цасанд норохгүй, хөлсөө сэвэхгүй байх,

Хүйтэн шингэн зүйлс уухгүй байх, хүйтэн зүйлст хүрэхгүй байх,

Хоол ундны нарийн дэглэм барьж хэт их идэхгүй хэт их өлөн явахгүй байх,

Архи, тамхи хэрэглэхгүй байх,

Эмчийн заалтгүйгээр дур мэдэн эмчилгээ хийлгэх бусад хүмүүсийн эмчилгээг даган дуурайж эмчилгээг өөрчлөхгүй байх

Эмчилгээ хийж байх үед саван, шампунь хэрэглэхгүй байх

Үйлчилгээ



Үйлчлүүлэгч чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд зориулж караоке, ширээний теннис, номын сан дэлгүүр болон кофе шопоор үйлчилж байна.

Нийтийн бүжиг, урлаг, спортын арга хэмжээ тусгай хөтөлбөрийн дагуу явагдана.

ХУЖИРТ РАШААН
СУВИЛАЛ ХХК
Утас: 77115858
www.hujirt.mn

Сувилалд хэрхэн ирж сувилуулах вэ?





1 Илгээх бичиг

Та манай илгээх бичгийг Улаанбаатар хот дахь Төлөөлөгчийн газраас эсвэл **www.hujirt.mn** веб сайтнаас татаж хэвлэж авна

2 ТАМГА

Та илгээх бичгээ өөрийн харъяа сум, өрхийн эмнэлгээр бөглүүлэн эмнэлгийн тамга даруулсан байна



4 Автобусны билет

Та Улаанбаатар хот дахь Төлөөлөгчийн газраас өрөө болон автобусны билетээ захиалж, төлбөрөө төлж баталгаажуулна

3 Шинжилгээ

Цус шээсний дэлгэрэнгүй шинжилгээ өгсөн байна. Хугарал болон үе мөчний өвчтэй бол өмнө нь авхуулсан рентген зургаа хавсаргаж болно



5 Захиалга

Хувийн унаагаар явах бол 77115858, 80498089 дугаарт залгаж урьдчилсан захиалж төлбөр тооцоог хийнэ

Улаанбаатар хот дахь Төлөөлөгчийн газар

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Боловсролын Их сургуулийн замын урд талд UBH center -ийн 10 давхарт 1006 тоот

Утас: **77115858**
80398089
80498089
91913860

www.hujirt.mn

Хужирт рашаан сувилал